



ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Гэрээний дугаар № Н-59-ХАГ-23/...

Хүчин төгөлдөр болох өдөр: 2023 он 07 дугаар сарын 24-ны өдөр

ҮНДСЭН НӨХЦӨЛ

1 ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээг нэг талаас Говь-Алтай аймгийн Тайшир сумын Засаг дарга Гармаа овогтой Болормаа (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Цэнгазар” ХХК-ны захирал Дашибаатар овогтой Даваа-Очир (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээ нь Говь-Алтай аймгийн Тайшир сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших Говь-Алтай аймгийн Тайшир сумын байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлнэ.

2 ГЭРЭЭНИЙ ХУГАЦААНД ХИЙГДЭХ АЖИЛ

- 2.1 Энэхүү гэрээний 5 дугаар зүйлд дурьсан хамтын ажиллагааны хороо нь гэрээний хугацаанд хийгдэх ажлыг тодорхойлох бөгөөд хэрэгжилтэнд хяналт тавин ажиллана.
- 2.2 Хамтын ажиллагааны хороо томилогдоогүй тохиолдолд талууд хийгдэх ажлыг харилцан тохиролцно.
- 2.3 Хийгдэх ажлын төсөв, санхүүжилтийг Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Засаг Даргын албан тоот хэлбэрээр ирүүлсэн төсөв дээр үндэслэн хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 2.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:
 - 2.4.1 **Хамтран ажиллах гэрээний хүрээнд:** Үүрэн холбооны сүлжээ сайжруулах /Юнител/, Ажлын байр нэмэгдүүлэх,
 - 2.4.2 **Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд:** Шинээр гүн ёрмийн худаг гаргах, /Далан баг/
 - 2.4.3 **Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд:** Жимсны мод услах ажлыг хялбар болгох,

3 ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 2.2 Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;
- 2.3 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч, саналыг нь авах;
- 2.4 Энэхүү гэрээний хэрэгжилтэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, түүнтэй зөвшилцөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;
- 2.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэх;
- 2.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;
- 2.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх.

4 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 4.1.1 Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;
- 4.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтад хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллага, мэргэжилтэнтэй хамтарч ажиллан, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;
- 4.1.3 Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;
- 4.1.4 Нийт ажлын байрны 40-с доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;
- 4.1.5 Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлэх;
- 4.1.6 Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг (сум, дүүрэг)-ийн иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;
- 4.1.7 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгоходо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;
- 4.1.8 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;
- 4.1.9 Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хучний болон бусад материаллаг туслалцаа узуулэх.

5 ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО

- 5.1 Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.
- 5.2 Хороо нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн 3-4 хүний төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшигүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.
- 5.3 Хороог Компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон дээд албан тушаалтан удирдан зохион байгуулж, хорооны үйл ажиллагааны сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд хагас жил буюу 6 сар тутамд тайлagnan ажиллана.
- 5.4 Хороо нь компанийн бизнесийн дотоод үйл ажиллагаанд шууд болон шууд бус хэлбэрээр оролцохгүй.

6 ХУГАЦАА

- 6.1 Энэхүү гэрээ нь 2024 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл хүчинтэй.

7 ХЭРЭГЖИЛТ

- 7.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг аймаг сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.
- 7.2 Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчийн Хуралд хүргүүлнэ.
- 7.3 Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

8 ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 8.1 Талууд гэрээгээр хулээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор

УЛААНБААТАР

ЦЭНГАЗ
ХХК

TTA4123 № 5086:



хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

- 8.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан эсэх талаарх мэдээллийг геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

9 МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1 Талууд гэрээний хэрэгжилтгэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хурч чадаагүй тохиолдолд гомдлоо шуухэд гаргаж болно.

10 ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 10.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилиэ.
 10.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талууд хэлэлцэн гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.
 10.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.
 10.4 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг англи хэл дээр үйлдэж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“Цэngазар” ХХК-ийг төлөөлж

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн
гудамж 24, М Плаза, 16-р давхар, 1604 тоот
Регистрийн дугаар: 5086353
Утас: 976-77772525

Хүлээн зөвшөөрсөн:

Нэр: Д.Даваа-Очир
Албан тушаал: Гүйцэтгэх Захирал
Утас: 976-88110372

Компанийг төлөөлөн харилцах албан тушаалтан:

Хүлээн зөвшөөрсөн:

Нэр: Б. Гомбодорж
Албан тушаал: Хүний нөөцийн менежер
Утас: 976-88080381

“Тайшир сум”-ыг төлөөлж

Хүлээн зөвшөөрсөн:

Нэр: Г. Болормаа
Албан тушаал: Тайшир сумын Засаг Дарга
Утас: 976-99718168

